

**“ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛ” БАКАЛАВРЫН
ХӨТӨЛБӨРИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН
(ШУТИС-ийн жишээн дээр)**

*Д. Одмаа
Доктор (Ph.D), дэд профессор*

*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль*

odmaadanga@gmail.com

*А. Ундраа
“Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн 2022 оны төгсөгч*

*Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль*

aundra1006@gmail.com

***Хураангуй:** ШУТИС-ийн Бизнесийн удирдлага Хүмүүнлэгийн сургуульд бэлтгэгдэж буй “Олон нийттэй харилцах ажил” бакалаврын хөтөлбөр нь 2009 оноос хэрэгжиж эхэлсэн, Монгол улсын хувьд анхдагч хөтөлбөр юм. “Олон нийттэй харилцах ажил” мэргэжлийн бакалаврын хөтөлбөрөөр суралцсан оюутнууд нь уг мэргэжлийн онолын мэдлэг, арга зүй, технологийг эзэмшихийн зэрэгцээ аливаа байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлан таниулах, эерэг дүр төрхийг бий болгох, нэр хүндийг өсгөх, удирдлага болон хамт олон руу чиглэсэн үр дүнтэй харилцааг бий болгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах зэрэг олон талт үр чадвартай мэргэжилтэн болж төгсдөг.*

Аливаа мэргэжилтний нэр хүнд, хөдөлмөрийн зах зээл дээрх үнэлэмж нь тухайн мэргэжилтэнг бэлтгэж буй сургалтын хөтөлбөр, оролцогч талуудын сэтгэл ханамжаас иүүд хамааралтай. Иймд тус хөтөлбөрийн сургалтын үйл явцад оролцогч талуудын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор судалгаа хийсэн. Энэ хүрээнд чанарын судалгааны аргаар сургалтын хөтөлбөрийн онолын үзэл баримтлал болон багш нар, ажил олгогчийн сэтгэл ханамж, тоон судалгааны аргаар хөтөлбөрт оролцогч бусад талуудын сэтгэл ханамжийг тус тус судалж, санал боловсруулсан.

***Түлхүүр үгс:** Боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр, хэрэгцээ шаардлага, багш, сурагцагч, төгсөгч, ажил олгогч*

УДИРТГАЛ

Улам бүр даяарчлагдаж буй өнөөгийн нийгмийн харилцааг өргөжүүлэхэд их дээд сургуулиудын бэлтгэн гаргаж буй мэргэжилтнүүдийн үүрэг, тэдний мэргэжлийн үр чадвар ихээхэн чухал болж байна. XXI зууныг мэдээ, мэдээлэл болон харилцааны зуун гэж судлаачид томъёолох болсон. Тиймээс мэдээлэл харилцааны орчинд олон нийтийн харилцааг удирдан

зохион байгуулах чадвар бүхий хөрвөх ур чадвартай олон нийттэй харилцах мэргэжилтнүүдийг нийгмийн бүхий л салбарт эрэлхийлж улмаар чухал хэрэгцээ шаардлагатай мэргэжлийн тоонд зүй ёсоор тооцогдох болсон [1].

“U.S.News a World Report”-ийн судалгаагаар хэвлэл мэдээллийн төрлийн мэргэжлүүдийн дэлхийн жагсаалтад 2021 оны байдлаар “Public Relations Specialist” буюу “Олон нийттэй харилцах мэргэжилтэн” гуравдугаарт эрэмбэлэгдэж байна. Тэд судалгаандаа олон нийттэй харилцах мэргэжилтний дундаж цалин хөлсний хэмжээ 72717\$ байх ба ажилгүйдлийн түвшин 1.1% байна гэж дүгнэжээ. Хөдөлмөрийн статистикийн товчоо 2019-2029 оны хооронд олон нийттэй харилцах мэргэжилтнүүдийн ажлын байр 7.2 хувиар нэмэгдэх, энэ хугацаанд ойролцоогоор 19,700 ажлын байр шинээр бий болох төлөвтэй байна гэж үзсэн. Олон улсын хэмжээнд тус хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг 60 орчим их дээд сургуулиуд байдаг бол манай улсад зөвхөн ШУТИС-ийн Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургууль мэргэжилтэн бэлтгэж байна [2]. Энэ хугацаанд бид сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг тасралтгүй шинэчлэн сайжруулж ажиллахын зэрэгцээ сургалтын болон материаллаг бааз, орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх, төлөвшүүлэх тал дээр анхааран ажиллаж ирсэн [3]. Гэвч өнөөг хүртэл олон нийтийн харилцаа мэргэжлийн талаар олон нийтийн дундах ойлголт хангалтгүй, байгууллагуудад энэ чиглэлийн бүтцийн нэгжгүй, нэгж байгуулсан ч тодорхой хугацааны дараа маркетинг, хэвлэл мэдээлэл зэрэг бусад нэгж салбартай нэгтгэн хавсарсан байдлаар хэрэгжиж байна. Нийгэмд олон нийтийн харилцааны мэргэжлийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэхийн хэрээр мэргэжилтний мэдлэг, ур чадварын асуудал урган гарч, ур чадвартай, онолын болоод практик мэдлэгтэй, чадварлаг боловсон хүчин бэлтгэгдэх нь тухайн сургуулийн сургалтын үйл явцаас шууд хамааралтай. Иймд сургалтын үйл явцад оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин хэр байгааг тодорхойлсны үндсэн дээр цаашид сайжруулах боломжийг эрэлхийлэх, хамтарч ажиллах нь чухал болоод байна.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Сургалтын хөтөлбөр нь тухайн боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг ямар эрэлт хэрэгцээ, үзэл баримтлалд тулгуурлан хэрхэн яаж зохион байгуулах, ямар орчин нөхцөл, санхүүгийн болон хүний нөөц байна, ямар менежментээр хөтөлбөрөө хэрэгжүүлэх зэрэг олон асуудлыг тусгасан цогц сургалтын баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл энэ нь боловсролын байгууллагын бодлогын баримт бичиг хийгээд арга зүйн удирдамж юм [4].

Сургалтын хөтөлбөрийн талаар судлаачид олон талаас нь судалж, өөр өөрийн онцлогтой онолуудыг боловсруулсан ч эдгээр нь бүгд сургалтыг хэрхэн үр дүнтэй явуулах вэ? Үүний тулд сургууль, сургалтын үйл явцад оролцогч талуудын зүгээс юун дээр анхаарах вэ? гэдэгт хариулт өгөхөд чиглэгддэг.

Зарим улс оронд нийгмийн шинжлэх ухааны сургалтад CDIO ((Conceive-бодож сэтгэх, design-төлөвлөж загварчлах, implement-хэрэгжүүлэх, operate-ажиллуулах) сургалтыг “Идэвхтэй сургалт”-ын арга технологиор явуулж, суралцагчдыг тодорхой даалгаврын дагуу багаар ажиллуулан инженерийн шийдэл гаргуулдагараа онцлог юм) системд суурилсан, карьерын өрсөлдөх чадварыг нэмэн оруулсан CCDIO буюу 2CDIO системийг хэрэглэх болсон. CDIO систем нь хэдийгээр инженерийн боловсролыг сайжруулах хувилбар боловч дутагдалтай нэг зүйл нь суралцагчдад зориулсан карьер хөгжүүлэлтийн асуудлыг орхигдуулсан явдал юм [5]. ОХУ-ын судлаач Г.С.Дьяконовын [6] үзэж байгаагаар орчин үеийн боловсролын инноваци нь хүний үйл ажиллагааг олон талт ажил мэргэжлийн болон амьдралын нөхцөл байдалд чиглүүлэх үүрэг хүлээж байна. Өөрөөр хэлбэл мэргэжил олгоно гэдэг нь хурдацтай хөгжин буй өнөөгийн нийгэмд хөлөө олж, амжилттай алхах чадварлаг мэргэжилтэнг бэлдэх явдал болсон. Тиймээс карьерийн асуудлыг сургалтын хөтөлбөрт тусган, түүний өрсөлдөх чадвар гэдэгт мэдлэг (карьер дээр суурилсан үр дүнтэй мэдлэг), ур чадвар (карьер дээр суурилсан үр дүнтэй ур чадвар), хандлага (карьер дээр суурилсан сайн ёс суртахуун бүхий эерэг хандлага)-ыг багтаан ойлгох болсон [7]. Эндээс үзвэл карьерийн өрсөлдөх чадвар нь мэдлэг, чадвар, хандлагаас шууд хамаарч байна.

CCDIO систем career, conceive, design, implement, operate гэсэн үгний товчлол бөгөөд NPIA (need, plan, implement, adjst) карьерийн үе шатыг мэргэжлийн чадамж олгох CDIO-гийн үе шаттай хослуулсан суралцагч төвтэй сургалтын шинэ загвар юм. Энэ нь суралцагчийг мэргэжил эзэмших явцад нь давхар карьерийн хөгжилд нь анхаарч, боломж олгодгоороо давуу талтай. CCDIO систем нь 2015 оноос эхлэн эрчимтэй яригдаж эхэлсэн бөгөөд одоогоор хамгийн дэвшилттэй сургалтын арга барил хэмээн тооцогдож байна. CCDIO дээр суурилсан сургалтын хөтөлбөр нь Карьерын хандлага болон энгийн ур чадвар, Инженерийн суурь мэдлэг, Инженерийн үндсэн чадамж, Инженерийн мэдлэг, ур чадварын хосолсон систем гэсэн 4 хэсгээс бүрддэг [8].

Суралцагчид их дээд сургуулийн сургалтын явцад онолын мэдлэг эзэмшдэг хэдий ч төгсөөд ажил эрхлэхэд шаардлагатай тодорхой ур чадварууд хангалтгүй эзэмшсэнтэй холбоотойгоор хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний шаардлагыг хангаж чаддаггүй. Иймд сургалтын хөтөлбөр боловсруулахдаа дэлхийн чиг хандлага, өөрийн орны онцлог, боловсролын

зорилго, стандарт, оролцогч талуудын сэтгэл ханамж, нийгмийн хэрэгцээ шаардлага, хүлээлт зэргийг харгалзан үзэх нь чухал юм.

Сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа нь хэрэгцээг тодруулах судалгаанаас эхлэх бөгөөд энэ нь тухайн сургалтын хөтөлбөрийн үндэслэл болдог. Энэ утгаараа манай улсад “Олон нийтийн харилцаа” мэргэжлийн хэрэгцээ шаардлага бий болж, зарим байгууллагууд бүтцийн нэгжтэй болсон явдал нь үндэсний мэргэжилтэн бэлтгэх нөхцлийг бүрдүүлж өгсөн. Олон нийттэй харилцах ажил мэргэжил бол хүн төрөлхтний эртний соёл иргэншилтэй хамт үүссэн нийгмийн харилцааны анхны элементүүдийг агуулсан сэтгэлгээний өвөрмөц салбар бөгөөд бие даасан мэргэжилтэн бэлтгэх үйл явц нь ХХ зууны эхэн үетэй холбогддог [9]. 1975 онд АНУ-д Олон нийтийн харилцааны сургалтын анхны стандарт гарсан бөгөөд 1981 онд шинэчилсэн байдаг. 1987 онд АНУ-ын Олон нийтийн харилцааны оюуны холбоо, мэргэжилтэн бэлтгэх болон ахисан түвшний сургалтын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж үүний үр дүнд магистр, докторын сургалтын шинэ хөтөлбөрийг боловсруулан 1997 оноос зайн сургалт явуулж эхэлсэн. Харин манай улсад ШУТИС-ийн Нийгмийн технологийн сургуулийн “Философи, улс төр, соёл судлал”-ын профессорын баг “Олон нийттэй харилцах ажил” мэргэжлийн бакалаврын ангийг 2009 онд Монгол анх удаа нээсэн [10]. ШУТИС-д уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон үндэслэл нь салбарын профессор, багш нараас гадна бусад бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран МХТС, ҮТС, ХШУС мэргэжлийн хичээлүүдийг хамтран зааж, байгууллагын олон нийттэй харилцах мэргэжилтэн болон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэх явдал байсан. Энэ үндсэн чиглэлээсээ хазайлгүйгээр бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг оролцогч талуудын сэтгэл ханамжид үндэслэн тасралтгүй шинэчлэн сайжруулахын зэрэгцээ орчин үеийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бакалавр, магистрын түвшинд сургалт явуулж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

“Олон нийттэй харилцах ажил” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцсан оюутнуудад уг мэргэжлийн онолын мэдлэг, арга зүй, технологийг эзэмшихийн зэрэгцээ аливаа байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээллэх, сурталчлан таниулах, эерэг дүр төрхийг бий болгох, нэр хүндийг өсгөх, удирдлага болон хамт олон руу чиглэсэн үр дүнтэй харилцааг бий болгох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг мэргэжлийн ур чадвараас гадна удирдан зохион байгуулах, багаар ажиллах, илтгэх, өөрийгөө хөгжүүлэх зэрэг карьерын олон талт ур чадварыг олгохыг эрмэлздэг. Тус мэргэжлийн бакалаврын

хөтөлбөрийг нийгэмд хэрэгжүүлснээр мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг өсгөх, чанартай төгсөгч бэлтгэж, мэргэжилтний ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, байгууллагуудыг мэргэжлийн “Олон нийттэй харилцах менежер”-ээр хангах гэсэн хүлээлттэйгээр сургалтын үйл ажиллагааг явуулж байна [11].

Энэхүү судалгаанд оролцогч талуудыг багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн хүрээнд авч үзэж, 8 багш, 27 суралагч, 27 төгсөгч, 10 ажил олгогчоос судалгаа авсан.

Багш нарын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн. ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургуулийн (БуХС) “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн багш нарын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор тус хөтөлбөрийн 8 багшаас 2021 оны 11 сарын 15-наас 11 сарын 28-ны хооронд ганцаарчилсан ярилцлагын аргаар 12 асуултын хүрээнд судалгаа авсан. Олон нийттэй харилцах ажил хөтөлбөрийн үндсэн багш нарын бүрэлдэхүүнд тус мэргэжлээр суурь мэргэжил эзэмшсэн багш байхгүй бөгөөд “Улс төр судлаач”, “Сэтгэл судлаач”, “Түүхч”, “Хэвлэлийн эх бэлтгэл, редактор”, “Социологич” зэрэг мэргэжилтэй, багшлаад 1-ээс 38 хүртэлх жилийн туршлагатай боловсон хүчин байв.

Судалгаанд оролцсон нийт багш нар “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрт тулгамдсан асуудал байгаа гэж үзсэн. Үүнд:

- Хөтөлбөрийн элсэгчдийн тоо сүүлийн жилүүдэд буурсан шалтгааныг боловсролын хямралтай холбож тайлбарласан ба сүүлийн жилүүдэд ЕБС төгсөгчдийн тоо бага болсноос үүдэж зөвхөн ОНХА хөтөлбөр гэлтгүй бусад хөтөлбөрийн элсэлт ч бага байгаа. Мөн түүнчлэн 2014 оны их дээд сургуулийн бүтцийн өөрчлөлт, тус хөтөлбөрийг бакалаврын биш магистрын түвшнийх байх хэрэгтэй гэж өөр олон мэргэжлийн хөтөлбөрийн хамт царцаасан. 1-р курсын намрын улиралд мэргэжлийн хичээл ордоггүйгээс суралцагчдад мэргэжлийн итгэл үнэмшил төрдөггүй, эхний улиралдаа шилжих тохиолдол их байна. Анх байсан багшлах боловсон хүчин ажиллахаа больсон, мэргэжил сурталчлах асуудал учир дутагдалтай зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.
- Багш нарын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн зүгээс олон арга хэмжээ авч хэрэгжүүлдэг хэдий ч мэргэжлийн сургалтад хамруулах, туршлага судлуулах, туслалцаа дэмжлэг үзүүлэх тал дээр учир дутагдалтай байна.
- Нийт судалгаанд хамрагдагчдын талаас илүү буюу 62.5% нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага, ойрын үед байгаа гэж үзсэн. Гэвч сургалтын хөтөлбөр,

төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудал хэт тогтсон хандлагатай, олон дамжлагатай, уян хатан биш, шийдвэр нь удаан гардаг байдал нь шинэчлэл хийх үйл явцад сөргөөр нөлөөлдөг.

- Төгсөгчдийн ажлын байран дээрх ажил эрхлэлт 80 хувь орчим буюу хангалттай сайн гэж зарим багш нар үзэж байхад зарим нь мэргэжлийн ажил эрхлэлт хангалтгүй хэмжээнд байна гэж дүгнэсэн. Иймд төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг индексжүүлж албан ёсны болгох шаардлагатай байгаа.
- Ном сурах бичгийн хомсдол, материаллаг баазын асуудал тулгамддаг. Хөтөлбөрийн ном, сурах бичгийн хангамж, хүрэлцээний тал дээр хангалтгүй байдаг. БуХС-ийн нэг улирлын хугацаанд 1 хөтөлбөрт 1 сая төгрөгний лимит өгдөг. Оюутнуудад монгол хэл дээр үндсэн сурах бичих хэрэглэх бололцоо хангалттай хэмжээнд хүрээгүй байна. Мөн нэг хичээлд дунджаар 2-3 ном ашигладаг ба нэг номны дундаж худалдан авалт хориос гучин мянган төгрөг байдаг. Ихэвчлэн гадаад хэл дээрх ном сурах бичгийг орчуулан ашигладаг.
- Байгууллагад дангаараа олон нийтийн харилцааны чиглэлээр ажиллаж буй нэгж хомс учир практик дадлага хийлгэх асуудал учир дутагдалтай.
- Ажил олгогч талтай хамтын ажиллагааг тэлж бэхжүүлэх асуудал тулгамдаад байгаа. Хөтөлбөрт оролцогч талуудын хамтын ажиллагааг сүүлийн жилүүдэд сайжирч байгаа хэдий ч хангалттай хэмжээнд биш байна.

Нийт судалгаанд хамрагдсан багш нар ОНХА хөтөлбөрийн сургалтын үйл явцыг ерөнхийд нь 74.7 хувиар үнэлсэн байна.

Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн. “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн суралцагчдын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор 2021 оны 11 сарын 15-наас 11 сарын 28-ны хооронд Google forms ашиглан онлайнаар нээлттэй судалгаа авсан. Тус судалгаанд ШУТИС-ийн Бизнесийн Удирдлага Хүмүүнлэгийн сургуулийн “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрөөр суралцаж буй 1-5 дугаар курсын бакалаврын түвшний 27 суралцагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан оролцогчдын 63% эмэгтэй, 37% нь эрэгтэй байсан бөгөөд насны хувьд 66.7% нь 19-21 насных, 25.9% нь 16-18 насны оролцогчид байв. Курсын хувьд 1-р курс 37%, 2-р курс 29.6%, төгсөх курс 33.3%-ийг эзэлж байна.


Суралцаж буй мэргэжлийнхээ хамгийн давуу талыг зах зээлд хөрвөх чадвар өндөр гэж 44.4% нь, 29.6% нь хувь хүний хөгжил зан төлөвт эерэг нөлөөтэй, 22.2% нь төгсөж гараад ажлын байртай, 3.7% нь Монгол улсад эрэлттэй мэргэжил гэж үзжээ. Харин мэргэжлийнхээ сул талыг дийлэнх

суралцагчид Монгол улсын хэмжээнд тийм ч сайн танигдаж, хөгжөөгүй, олон нийтийн дунд хар PR гэх ойлголт түгээмэл байдгаас мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг ойлгохгүй байх олон нийтийн хандлага түгээмэл гэжээ.


Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд таны мэргэжил эзэмших, хөгжих хэрэгцээтэй хэрхэн нийцэж байгаа талаар тодруулахад 25.9% нь бүрэн нийцэж байгаа, 70.4% нь зарим талаараа нийцэж байгаа, 3.7% нь мэдэхгүй гэж хариулсан бол огт нийцэхгүй байгаа гэсэн хариултыг 1 ч оролцогч сонгоогүй байна.

Суралцагчид өөрсдийн үзэл бодолд тулгуурлан суралцаж буй мэргэжлийн хөтөлбөрөө 9 үзүүлэлтээр үнэлсэн ба ОНХА хөтөлбөрийн сургалтын үйл явцыг ерөнхийд нь үнэлэхдээ нийт судалгаанд оролцогчдын 30% нь 5 буюу маш сайн, 38% нь сайн, 32% нь дунд буюу түүнээс муу гэж үнэлсэн.

Уг үзүүлэлтүүдээс харахад суралцагчид мэргэжлийн хөтөлбөрөөр




зайлшгүй эзэмших ёстой мэдлэг, ур чадвар, дадлыг эзэмшиж чадаж байгаа бөгөөд сургалтын техник хэрэгслийн хангамж, ном сурах бичиг зэрэг зарим хүчин зүйлсийн хүрэлцээ хангамж тийм ч сайн биш байгаа нь харагдаж байна.




Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага ойрын үед байгаа юу? гэсэн асуултанд 46.2% нь тийм, 34.6% нь магадгүй, 19.2% нь үгүй гэж хариулсанаас үзэхэд “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэж байна.


Тус мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчид хичээлийн явц, үр дүн, багшийн ур чадварт дараах байдлаар үнэлгээ өгсөн ба ерөнхий үзүүлэлтээр сайн буюу маш сайн гэж үнэлсэн байна. Харин танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэх боломжийг ихэнх суралцагчид дундаж гэж үнэлсэн байна.



Судалгаанд хамрагдсан суралцагчдад суралцаж буй мэргэжлийн чиглэлээс гадна “карьер хөгжүүлэлтийн сургалт”, “хувь хүний төлөвшил, нийгэм-сэтгэл зүйн мэдлэг”, “харилцааны соёл, техник үр чадвар” зэрэг салбарын мэдлэг чухал хэрэгцээтэй гэж дүгнэсэн.




ОНХА сургалтын хөтөлбөрийн багш нарын практик арга барил, ур чадварыг нэмэгдүүлэх, цар тахлын улмаас цахимаар орсон дийлэнх хичээлүүд үр дүнгүй байсан тул агуулгыг нөхөн олгох шаардлагатай байна гэж үзсэн.




Хөтөлбөрийн оюутнууд мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг хэмээн 74.1% нь хариулжээ. Судалгаанд оролцогчид сонгосон мэргэжилдээ тал хувь нь буюу 51.9% нь маш их сонирхолтой, 37% нь сонирхолтой гэж хариулсан байна.

Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн. Олон нийттэй харилцах ажил хөтөлбөрөөр төгсөгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох зорилгоор 2021 оны 11 сарын 15-наас 11 сарын 28-ны хооронд мөн Google forms ашиглан онлайнаар нээлттэй судалгаа авсан. Тус сургуулийн “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрөөр 2013-2021 онд төгссөн 27 төгсөгч хамрагдсан. Нийт судалгаанд хамрагдагчдын 66.7 хувь нь мэргэжлээр ажиллаж байгаа гэсэн хариулт өгсөн.




Судалгаанд оролцогчдын одоогийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 7% нь ажилгүй, 8% нь жирэмсний амралттай, 11% нь суралцаж байна, 74% нь ажил эрхэлж байна. Ажил эрхэлж буй төгсөгчдийн тал хувь нь бизнесийн байгууллагад, 25% нь хувийн хэвшилд, 17% нь төрийн байгууллагад үлдсэн хэсэг нь мэргэжлийн агентлаг болон бусад ангилалд багтаж байв.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын одоогийн албан тушаалд анализ хийхэд эхлэл болоод дунд түвшний гүйцэтгэх албан тушаалд түлхүү байна. ОНХА мэргэжил нь шинээр бий болоод удаагүйн сацуу тухайн мэргэжлээр анхны төгсөгчид төгсөж гараад төдийлөн удаагүй билээ.



Сургуулиа төгсөөд үндсэн ажилд ороход шаардагдсан хугацааг харахад 3 сарын дотор ажилд орсон үзүүлэлт 33.3 хувьтай байна. Суралцаж байх хугацаандаа ч ажилд орох нь элбэг байгаагаас үзэхэд тухайн мэргэжлээр төгсөж буй төгсөгчдийн мэргэжлийн болоод хувийн ур чадвар өндөр байгааг илтгэж байна.




Төгсөгчид маань өнгөрсөн хугацаанд 11.1 хувь нь нэг удаа, 22.2 хувь нь хоёр удаа, 11.1 хувь нь гурван удаа, мөн 11.1 хувь нь 4 удаа, 3.7 хувь нь 5 удаа ажлын байраа сольсон бол үлдсэн 40.7 хувь нь анх ажилд орсон байгууллагадаа ажилласан хэвээр байна.

Төгсөгчид төгссөн сургуулиа дараах үзүүлэлтүүдээр үнэлсэн ба (1 буюу тун хангалтгүй, 2 буюу хангалтгүй, 3 буюу боломжийн, 4 буюу сайн, 5 буюу маш сайн) сургалтын албаны үйлчилгээ, цайны газрын үйлчилгээ, оюутны байрны үйлчилгээ, сургуулийн дотоод орны тав тух, төгсөгчдийн холбооны үйл



ажиллагаа зэрэг анхаарах асуудлууд байгааг харуулж байна.

Зураг 10. Төгсөгчид төгссөн сургуулиа үнэлсэн байдал



Ажлын карьераа 7.4% нь маш амжилттай, 44.4% нь ерөнхийдөө амжилттай, 44.4% нь дунд зэргийн амжилттай хэмээн хэмээн үнэлсэн ба БуХС (НТС)-д олж авсан боловсрол нь ажлын карьерт 22.2 хувьд нь маш их хэрэг болсон, 44.4 хувьд нь бага зэрэг хэрэг болсон гэж үзжээ. Тус мэргэжлээр төгсөгчдийн давуу талыг хөрвөх чадвар сайтай, харилцааны өндөр чадвартай, нэр хүндтэй сургуулийн төгсөгч гэж дүгнэсэн бол сул талыг гадаад хэлний мэдлэг тааруу, мэргэжлийн итгэл үнэмшил сул, ажлын талбар дах ажил үүргийн хуваарь тодорхой бус гэжээ.

Судалгаанд оролцогчид баклавын төгсөлтийн дараах магистрын сургалтад хамрагдсан байдал нь 18.5 хувь нь сураад төгссөн, 11.1 хувь нь одоо суралцаж байгаа, 51.9 хувь нь суралцаагүй боловч суралцах төлөвлөгөөтэй байгаа, 18.5 хувь нь суралцах төлөвлөгөөгүй байна.

Хөтөлбөрийн давуу болоод сул талыг дараах байдлаар үнэлснээс үзэхэд Монгол улсын хэмжээнд анхдагч шинэ мэргэжил учир нийгэмд тийм ч сайн танигдаж байр сууриа олоогүй, өрсөлдөгчгүй байгаа нь нөгөө талаараа сул тал болж байна. Аливаа зүйл өрсөлдөгч байх нь тухайн хүчин зүйл илүү сайн хөгжих хөшүүрэг болж өгдөг. Бий болоод цөөхөн жилийн хугацаа өнгөрч буй учир мэргэжлийн багшлах боловсон хүчин болоод туршлага дутмаг байгаа хэдий ч хөтөлбөрийн багш болоод бодлого боловсруулагчид цаг үетэйгээ нийлүүлэн судалгаа шинжилгээ хийж хөтөлбөрийн шинэчлэлт хийсээр байна.

Төгсөгчид тус сургуулийг Олон нийттэй харилцах ажил мэргэжлээр төгссөндөө 7.4 хувь нь маш сэтгэл хангалуун, 25.9 хувь нь сэтгэл хангалуун, 51.9 хувь нь боломжийн түвшинд сэтгэл ханамжтай байна гэж үнэлсэн.

Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн. Олон нийттэй харилцах ажил хөтөлбөр, сургалтын үйл явц, түүний үр дүнг үнэлэх, цаашид илүү сайжруулах арга замыг олж нээх зорилготойгоор чанарын судалгааны буюу ганцаарчилсан ярилцлагын аргаар тус салбарын 10 ажил олгогчоос судалгаа авсан. Судалгаанд оролцсон нийт ажил олгогчдын 80 хувь нь эмэгтэй, 20 хувь нь эрэгтэй байсан ба насны хувьд 26-35 насныхан 60 хувь, үлдсэн 40 хувийг 36-45 насныхан эзэлж байна.

Судалгаанд оролцогч байгууллагуудын 90 хувь нь Олон нийттэй харилцах ажилтантай ба 1-9 жилийн хугацаанд олон нийттэй харилцах мэргэжилтэнтэй хамтарч ажиллаж байгаа. Судалгаанд оролцсон ажил олгогч нар ШУТИС-ийн төгсөгч Олон нийттэй харилцах ажилтанг 1-5 хүртэлх дарааллаар үнэлсэн ба үнэлгээний дундаж нь мэргэжлийн мэдлэгийн хувьд 3.6, мэргэжлийн ур чадварын хувьд 3.5, хувь хүний харилцаа хандлага, төлөвшлийн хувьд 4.6 гэж тус тус үнэлжээ. Үүнээс үзэхэд төгсөгчид маань мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд хангалттай бус хэмжээнд байгаа нь харагдаж байна. Харин хувь хүний харилцаа хандлага, төлөвшлийн хувьд өндөр үзүүлэлттэй байна. Ерөнхийдөө манай төгсөгчид ажил олгогчдын сэтгэл ханамж, хүлээлтэд нийцэж байгаа гэдгийг илэрхийлсэн.

ШУТИС-ийн “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрөөр төгсөгчийн дутагдалтай мэдлэг, чадвар, дадал, хандлагыг нэрлэхдээ:

- Техник технологийн ур чадвар дутмаг
- Анализ, дүн шинжилгээ хийхдээ сул
- Бусдыг манлайлан, шинийг санаачлахдаа тааруу
- Бичих ур чадвар сайн хөгжөөгүй
- Гадаад хэлний мэдлэг хангалтгүй

Харин ШУТИС-ийн төгсөгч Олон нийттэй харилцах ажилтны бусад ажилтнаас ялгагдах онцлог, давуу талыг нэрлэхдээ:

- Няхуур, нямбай, хариуцлагатай

- Хуваарийн дагуу өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэдэг ба аливаа зүйлийг лавлаж, тодруулж асуудаг
- Нээлттэй, өөртөө итгэлтэй, биеэ даасан, эрч хүчтэй
- Харилцааны чадвар сайтай
- Найдвартай, найдаж болохуйц
- Суралцах хүсэл, хандлагатай
- Судалгаа хийх чадвар сайн
- Ажилдаа хандах хандлага сайн
- Менежмент ийн ур чадвар сайтай
- Зөөлөн ур чадвар сайн эзэмшсэн

Судалгаанд хамрагдсан оролцогчид цаашдаа ШУТИС-ийн төгсөгч Олон нийттэй харилцах ажилтанд ажил олгосон хэвээр байна гэлээ. Тэдний дийлэнх нь оюутан дадлагажуулах цаашлаад хүний нөөцийн бааз бүрдүүлэх, төсөл хөтөлбөрт хамтарч ажиллах, сайн дурын ажилд оюутнуудыг татан оролцуулах, сургалт семинар харилцан өгч, авалцах зэрэг байдлаар хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн БУХС-ийн “Олон нийттэй харилцах ажил” хөтөлбөрийн сургалтын үйл явцад хийсэн шинжилгээний үр дүнгээс харахад тус сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага байна хэмээн хөтөлбөрийн оролцогч талуудын дийлэнх нь үзсэн учраас ойрын үед шинэчлэл хийх хэрэгтэй байна.

Хөтөлбөрийн хувьд оролцогч тал болох суралцагч болон багш нарын сэтгэл ханамжийн түвшин боломжийн, төгсөгч болоод ажил олгогчийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай гэсэн судалгааны үр дүн гарсан. Цаашид төгсөгчид болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн үнэлгээнд сөргөөр нөлөөлсөн хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

САНАЛ

“Олон нийттэй харилцах ажил” бакалаврын хөтөлбөрийн оролцогч талууд сэтгэл ханамжийг судалсны үндсэн дээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Багш нар “Тус хөтөлбөрийн элсэгчдийн тоог нэмэгдүүлэх тал дээр өмнөх уламжлалт маркетингийн бодлогоо өөрчлөх, Тухайн мэргэжлийг нийгэмд таниулах гол субъект төгсөгчид байдаг учир төгсөгчидтэй хамтран ажиллах, хос хөтөлбөр, 2+2 хөтөлбөр хэрэгжүүлэх, Мэргэжлийн багшлах боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, ШУТИС нь

тогтсон инженер, технологийн мэргэжилдээ ач холбогдол өгч бусад мэргэжлийн хөтөлбөрийн элсэлтээ орхигдуулдгийг анхаарах, Сургалтын чанар, сургуулийн орчинг (ном, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн кабинет, студитэй болгох) сайжруулах, Ажил олгогчтой хамтрах ажиллах, тэдний хүлээлтэд нийцэхүйц мэргэжилтэнг бэлтгэхэд хамтын ажиллагаагаа сайжруулах хэрэгтэй” зэрэг саналуудыг дэвшүүлсэн.

2. Тус хөтөлбөрийн суралцагчид тус хөтөлбөрийнхөө сургалтын үйл явцыг хэрхэн сайжруулж болох талаар саналаа дараах байдлаар илэрхийлсэн байна. Үүнд: “Онолын бус практик мэдлэг олгох, кейс дээр ажиллуулах, Олон улсын сургалтын хөтөлбөртэй одоогийн сургалтын хөтөлбөрөө харьцуулах байдлаар сайжруулах, Мэргэжлийн ном сурах бичгийн хангамжийг дээшлүүлэх, Олон нийт рүү чиглэсэн эвент, сайн дурын ажлыг зохион байгуулах, Зарим хичээлийн агуулгыг шинэчлэн, баяжуулах, Сургалтын орчинг сайжруулах” хэрэгтэй гэжээ.

3. Төгсөгчид тус хөтөлбөрийнхөө сургалтын үйл явцыг хэрхэн сайжруулж болох талаар “Багшлах боловсон хүчний асуудалд анхаарлаа хандуулж, сайжруулах, Оюутнуудыг мэргэжлийн үнэ цэнэ, бахархалтай болгох, PR-ийн салбар хөгжсөн орнуудын төрөл бүрийн салбарын кэйс дээр задлан шинжилгээ хийлгэх, сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх, Нэр хүндтэй манлайлагчдыг урин лекц, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах, Элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, Төгсөгчдөөс туршлага судлах хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зэрэг саналуудыг дэвшүүлсэн.

4. Ажил олгогчдын зүгээс ОНХА хөтөлбөрийн сургалтын үйл явцыг илүү сайжруулах дараах саналуудыг өгсөн. Тухайлбал, “MS. Excel програм дээр харьцуулсан дүгнэлт гаргах зэрэг оффис программ дээр ажиллах, техник технологийн ур чадвар эзэмшүүлэх, Биений хэлэмж буюу үгэн бус харилцааны мэдлэг олгох, Практик арга барил сайн эзэмшүүлэх, Бусад салбарын олон талт мэдлэг олгох, Бичих ур чадварыг сайжруулах, Зураг янзлах, видео эвлүүлэг хийх зэрэг технологийн ур чадварт анхаарах, Бизнесийн төлөвлөлт, компанийн процесс загварын талаар мэдлэг олгох, Гадаад хэлний мэдлэг сайн эзэмшүүлэх” хэрэгтэй гэж үзсэн.

НОМ ЗҮЙ

[1] Нийгмийн хөгжил: Асуудал, шийдэл сэтгүүл. Одмаа Д. Дээд боловсролын салбар дахь PR-ийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол. УБ., 2015. х 126

[2] Ундраа А. “Олон нийттэй харилцах ажил” бакалаврын сургалтын хөтөлбөрт хийсэн шинжилгээ дипломын ажил. УБ., 2022. х 4

[3] Одмаа Д. Судалгааны бүтээлийн товчоон. УБ., 2018. х 226

[4] Одмаа Д. Сургалтын хөтөлбөр боловсруулах онол, арга зүй. УБ., 2019. х 61

[5] Одмаа Д. Сургалтын хөтөлбөр боловсруулах онол, арга зүй. УБ., 2019. х 57

[6] Дьяконовыи.Г.С. и.др. Особенности инновационного инженерного образования //Вестник Казанского технологического университета №12. 2010.стр 13-17

[7] Management and innovation scientific journal. Odmaa D and Buyankhishig J. Research on opportunities to implement CCDIO system in the social sciences' program. ICIED 2016. p 113

[8] World Transactions on Engineering and Technology Education. Zhenhua Liu. An analysis of the curriculum for water supply and drainage, science and engineering, based on CCDIO. Vol.13, No.4, 2015.p 585

[9] ШУТИС. Олон нийттэй харилцах ажил. УБ., 2013. х 21

[10] Одмаа Д. “Олон нийттэй харилцах ажил” мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга. УБ., 2019. х 4

[11] “Олон нийттэй харилцах ажил” бакалаврын сургалт, судалгааны ажлын хөтөлбөр. УБ., 2018. х 8